

ДеФакто **ТОЙМ**

➤ **БИЗНЕСМЕНҮҮДИЙГ
БАРИВЧИЛСАН ШАЛТГААН**

➤ **ТӨГРӨГИЙН ХАНШ 8.9
ХУВИАР СУЛАРСАН БАЙНА**

➤ **ТӨРИЙН БАНКААР
ДАМЖУУЛЖ МӨНГӨ
УГААСАН УУ?**

IX НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

МОНГОЛЫН ШИНЭ ЭКСПОРТ

II НҮҮРТ



НИЙТЛЭЛ

А.Бат-Оргил
Бодлогын судлаач

Засаглал гэх
"ШИДЭТ" ҮГ

V НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.01.31, №83

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn





Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

МОНГОЛЫН ШИНЭ ЭКСПОРТ

Гадаадад түр болон урт хугацаагаар амьдрах, эсвэл цагаачлах нь зөвхөн Монголд биш, дэлхий нийтээр түгээмэл үзэгдэл болжээ. Улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн хямралд өртсөн Венесуэлээс гэхэд л эдүгээ хүн амын арван хувь буюу гурван сая иргэн нь гадаадад дүрвэсэн, ирэх

жил 2 саяар [нэмэгдэх](#) гэнэ ээ. Эдийн засаг, улс төр, хувь хүний хүсэл зэрэг олон шалтгаантай, дэлхий нийтийн түгээмэл болсон энэ үзэгдлийг ардчилсан улс оронд хэн ч хүчээр зогсоож чадахгүй, боломжгүй. Энэ нүүдлийг ухаалгаар удирдах сорилт Монгол улсад тулгарлаа.

ИХ НҮҮДЛИЙН ГОЛ ШАЛТГААН

Монгол 3.2 сая хүнтэй, түүний 4.5 хувь нь гадаадад амьдарч байна. 2017 онд Гадаад Харилцааны Яамнаас гадаадад сурч, ажиллаж буй иргэдийн тоог гаргажээ. Дэлхийн 67 оронд 144,566 буюу Баянхонгор, Булган аймгуудын хүн амтай тэнцэх тооны монголчууд гадаадад амьдарч байна. Үүнээс 18 хүртэлх насны 23,990; 18-аас дээш насны суралцаж буй 25,986; албан ёсоор хөдөлмөр эрхэлж буй 26,697 хүн байгаа ажээ. 2018 онд Монгол улсын харьяатаас 490 хүн татгалзжээ.

Гадаадад амьдарч буйн шалтгааныг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ажилгүйдэлтэй холбон тайлбарладаг ч бодит шалтгааныг дэлгэрэнгүй судлаж, ангилах шаардлагатай.

Хамгийн гол шалтгаан нь Монгол улсын эдийн засагтай холбоотой. Иргэд амьдралаа авч явах хэмжээний орлоготой ажил олох боломжгүй, хувийн бизнесээ эрхлэх орчин нөхцөл байхгүй байна. Төр засаг дахь авлигаас болоод шударгаар өрсөлдөх боломжгүй, зээлийн хүү өндөр, татварын дарамт ч их. Монголбанкны мэдээлснээр 2018 онд хувь хүнд олгох банкны зээлийн дундаж хүү жилийн 18, аж ахуйн нэгжид бол 15.5 хувь байна. Бизнес эхлэхэд шууд л татвар авдаг, бусад орон шиг татварын чөлөө олгодоггүй. ЖДҮ-ийг дэмжих төсвийн хөрөнгийг

нь хууль тогтоогчид өөрсдөө авчихдаг болжээ. Бас салбарынхаа сайдын компанитай хэн өрсөлдөж чадах билээ.

Дараагийн том шалтгаан бол нийгмийн асуудал. Иргэд ажилгүй учир ядуу, ядуу учир бухимдалтай байна. Нийслэлийн нийтийн эзэмшлийн газруудыг хотын дарга нар нь хуваагаад авчихсан учир замын түгжрэл нь нийгмийн хөгжлийг гацаах боллоо. Хүн амын хагас нь буй нийслэл хотын агаарын бохирдол нь өдрийн цагаар урд талын машин харагдахгүй түвшинд очжээ. Олон мянган хүүхэд утаанд хордон нас барж байна. Энэхүү түгжрэл, хорт утаа, нийгмийн шударга бус явдал газар авч иргэдийн бухимдал тэнгэрт хүрч, ирээдүйдээ итгэх нь навс унаж байна. Нийгмийн шударга бус байдал ямар ч үнээр хамаагүй хурдан баяжих хүслийг өдөөж байна. Ихэнх иргэд гадагшаа явахыг хичээх болов. Өмнөд Солонгост одоо 46 мянган монгол хүн амьдарч буйгаас тал нь хууль бусаар, тэдний хагас нь ажил хайж байна.

Гурав дахь бүлэг шалтгаан бол гадаадын өндөр хөгжилтэй оронд сурч боловсрох, эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ авах, аялаж жуулчлах урсгал юм. Мөн гадаадын иргэдтэй гэр бүл болж байгаа хүмүүсийн тоо нэмэгдсээр байна. ►►

► ҮР ДАГАВАР

Монголд бараг өрх бүрээс хэн нэгэн нь гадаадад ажиллаж, ар гэрээ тэжээж байгаа. Дэлхийн Банкны [тайлангаар](#) гадаадаас Монгол руу 2010 онд 266 сая доллар шилжүүлж байсан бол 2018 онд 332 сая доллар болсон нь ДНБ-ий 2.7 хувьтай тэнцжээ. Монголд бүтэн жилд олдог орлогоо Солонгост хоёр сар биеийн хүчний ажил хийгээд олчихдог гэлцэнэ. Татварын мөнгөөр дарга нар нь, хамаатныхаа мөнгөөр иргэд нь тансаглаж байна.

Энэ их нүүдлээр Монгол улс оюуны чадавхтай, эрсдэл даах чадвартай, ид залуу хөдөлмөрийн нөөцөө экспортлож байгаа нь нийгэмд сөрөг нөлөө авчирч, олон айл “хагас гэр бүл”-тэй болоод байна. Эх, эцгийнхээ аль нэггүйгээр хүүхдүүд өсч, гон биеэр залуу насаа өнгөрүүлж байгаа эцэг эхчүүд олон болов. Гадаадад

ажиллагсад ихэвчлэн нийгмийн дундаж давхаргыг бүрдүүлэгчид, эсвэл ид хийж бүтээх насны залуус байна. Энэ байдлаараа бол Монгол улс хөдөлмөрийн нөөцийн хомсдолд орж, хэт баян цөөхөн гэр бүл болон эмзэг ядуу бүлгийнхэн л үлдэх шинжтэй.

Их нүүдлийн эерэг үр дагавар гэвэл монголчууд гадны орноос өндөр боловсрол, өөр соёл, гадаад хэл, технологи сурч биет бус хөрөнгө оруулалт хийгдэж байгаа явдал. Мөн эмнэлэг, боловсрол, нийтийн тээврийн үйлчилгээний ачааллыг тодорхой хэмжээгээр бууруулж байгаа юм.

Их нүүдлийн цувааны эерэг, сөрөг талыг харьцуулан, алсын хараатай, ухаалаг аргаар чиглүүлэх шаардлага бидний өмнө тулгараад байна.

УХААЛАГ БОДЛОГО

Зарим хүмүүс гадаадад амьдарч, эсвэл цагаачилж буй иргэдийг нүд үзүүлж, шууд буруутгаж байна. Тэгэхийн оронд тэднийг илүүтэй ойлгох, төр засаг нь шалтгааныг нь судлаж, урт хугацаандаа шийдэх аргаа олох учиртай.

Дээр дурдсан эерэг болон сөрөг талуудыг ухаалгаар удирдаж эерэг талыг нь өргөтгөж, өгөөжтэй ашиглах, гадаадад байгаа иргэдээ түлхэх биш, татах бодлого гаргаж, хэрэгжүүлэх цаг болжээ. Энэ ажлыг юуны өмнө гуравдагч хөршийн бодлогоор зохицуулж, тэдгээр орны иргэд болсон монголчуудад давхар иргэншилтэй байхыг зөвшөөрөхөөс эхлэж болох юм.

Дараагийн чухал алхам бол соёлын буюу зөөлөн хүчний бодлого. Монгол хүн гэдэг нь юуны түрүүнд Монгол хэлээ эзэмшихийг хэлнэ. Гадаадад байгаа хүүхдийг хэлээ сурахад нь бүх талаар туслаж дэмжих шаардлагатай байна. Эх эцэг нь гэртээ ядаж монголоор ярьж хэвших, унших, сонсох үлгэрийн номоор бүрэн хангах, ашиглахыг нь урамшуулах хэрэгтэй байна. Хүүхдүүд хоёр унаган хэлтэй байж өрсөлдөх чадвартай болно гэдгийг үргэлж санах хэрэгтэй. Монголчууд олноороо амьдарч буй улсуудад суугаа элчин сайдын яамдууд, консулын газрууд энэ талаар онцгой анхаарч, идэвх санаачилгатай ажиллах цаг болжээ.

Гадаадаас иргэдээ буцаж ирүүлэх оролдлого хийж байсны жишээ бол 2011 онд Сү.Батболдын Засгийн газраас хэрэгжүүлсэн Зөгийн үүр, 2016 онд Ч.Сайханбилэгийн Засгийн газрын баталсан Дэлхийн Монголчууд хөтөлбөрүүд юм. Төр засгийн цөөн хэдэн албан тушаалаас өөр ажил олгож чадаагүй, хувийн бизнес хийхэд нь чиглэл, боломж өгөөгүй, татварын бодлогоор дэмжээгүй учир олон тоогоор хүмүүс ирээгүй, эдүгээ зарим нь буцаад гадагшаа явсан байна.

Одоогийн нөхцөлд бид том том бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэхээс илүүтэйгээр бага, багаар итгэл олох үйл ажиллагаа явуулах нь зохистой. Тухайлбал төр засгаас бодлогоор ажиллах хүч явуулж байгаа бол, буцаад ирэхэд нь ямар ажлын байр бэлэн байхыг бодолцох хэрэгтэй. Япон руу олноороо явсан залуучуудад тухайн мэргэжлийн Японы сертификат авах боломж олгох, буцаад ирэхэд нь Монголд сурсан чиглэлээрээ ажиллах боломж олгоход анхаарна гэсэн үг.

Нөгөө талаасаа гадаадад амжилттай ажиллаж буй хүмүүсийн жишээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр маш их гаргадаг шигээ, Монголдоо ирээд амжилттай ажиллаж буй жишээг түлхүү харуулах хэрэгтэй байна.

2019.01.30

Эдийн засагч, нийтлэлч Д.ЖАРГАЛСАЙХАН

“ЭРХ ЧӨЛӨӨ”

гурвал ном



ИНТЕРНОМ НОМЫН ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРУУДААР
ХУДАЛДААЛАГДАЖ БАЙНА

+ (976) 9410 9342



НИЙТЛЭЛ

Алтанхуягийн БАТ-ОРГИЛ

Бодлогын судлаач

Засаглал гэх “ШИДЭТ” ҮГ

Засаглал гэх үг сүүлийн үед хаа саагүй харагдах болсныг та анзаарсан байх. Ялангуяа ерөнхийлөгчийн засаглал уу, парламентийн засаглал уу гэх мэтгэлцээн эрчимжсэнтэй холбоотойгоор хүн бүр ярих

болжээ. Гэхдээ “засаглал” гэх энэ үгийг олон улсын байгууллагууд моодонд оруулсан юм. Хөгжиж буй манайх шиг орны эдийн засаг, улс төрийн хөгжилтэй холбоотой бүхий л асуудалд “засаглал” л ганц шийдэл мэт ойлгогдох болжээ.

ЗАСАГЛАЛ ГЭЖ ЮУ БИШ ВЭ?

Монголчууд бид ерөнхийлөгчийн засаглал, парламентийн засаглал гэж их ярьж, мэтгэлцэж байна. Тэгэхээр энэ хоёр үгийг англи хэл рүү хөрвүүлвэл presidential governance, parliamentary governance гэж бууна. Улс төр судлалын ямар ч сурах бичгийг нээгээд харсан ийм нэр томьёо байдаггүй. Харин parliamentary system and presidential system буюу парламентийн тогтолцоо, ерөнхийлөгчийн тогтолцоо гэж нэрлэсэн байгааг харах болно. Нэр томьёоны энэ эндүүрлийг манай үндсэн хуулийн эцэг Б.Чимид (2008) “Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудлууд” номондоо дурдсан байдаг. Б.Чимид гуай парламентийн, ерөнхийлөгчийн гэх нь засаглал хэлбэр биш бөгөөд энэ нь төрийн удирдлагын хэлбэр гэжээ.

Зарим хүмүүс ардчилсан засаглал гэж ярьдаг. Ер нь ардчилал бол дэглэм юм. Улс төрийн ухаанд улс орнуудыг төрийн дэглэмээр нь ардчилсан, авторитари, тоталитари гэж гурав хуваадаг. Эрх мэдэл хэрхэн хэрэгжиж байгаагаар энэ дэглэмүүд ялгагдана.

Бидний бас нэг яриад хэвшчихсэн нэр томьёо бол “компанийн засаглал”. Гэтэл мөн л англи хэлэнд “company governance” гэж хэлдэггүй. Харин “corporate governance” буюу “корпорацийн засаглал” гэж хэлдэг. Ер нь яагаад компанийн засаглал гэхгүй корпорацийн засаглал гэж нэрлэсэн нь тодорхой шалтгаантай бөгөөд уг шалтгааныг би энэ нийтлэлдээ тайлбарлах юм.

ТЭГВЭЛ ЗАСАГЛАЛ ГЭЖ ЧУХАМ ЮУ ЮМ БЭ?

Эхлээд нэг ойлголтыг тайлбарлах хэрэгтэй. Эдийн засгийн ухаанд “Principal agent problem” буюу эзэн албатын проблем гэж бий. Товчхондоо албат нь эзний өмнөөс шийдвэр гаргахтай холбоотойгоор үүсдэг проблем гэж ойлгож болно. Жишээлбэл төр, ард түмэн хоёрын хооронд үүснэ. Эзэд буюу ард түмний өмнөөс

албатууд буюу төрийн албан хаагчид шийдвэр гаргадаг. Ийм үед эзний зүгээс албатуудын гаргаж байгаа шийдвэр нь зөв эсэх, тал тохой татсан эсэх, өөртөө ашиг хонжоо хайсан эсэх гэх мэт олон зүйлийг хянах шаардлага тулгарна.

Корпорацийн хувьд эзэн болох олон мянган

хувьцаа эзэмшигчдийн өмнөөс менежментийн баг буюу албатууд шийдвэр гаргадаг. Корпорацийн жинхэнэ эзэд болох хувьцаа эзэмшигчид өөрсдийнх нь хөрөнгийг үр дүнтэй зарцуулж байгаа эсэх, зөв зүйлд хөрөнгө оруулалт хийж байна уу гэх мэт олон талаас нь хянах, хариуцлага тооцох хэрэгцээ мөн адил үүсдэг. Энд нэг том асуудал байгаа нь эзэд нь хэт олон, албат нь цөөн. Корпорацийн тухайд л гэхэд хэдэн арван мянган хувьцаа эзэмшигч байдаг бол төрийн тухайд иргэд нь хэдэн саяар тоологдоно. Ерөөсөө л энэ асуудлыг шийдэх зорилготойгоор “засаглал” гэдэг ойлголт гарч ирсэн гэхэд буруудахгүй. Та ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо, тайлагнах зэрэг үгнүүд яагаад засаглал гэдэг үгийг салшгүй дагаж явдгийг бодож үзсэн үү? Ерөөсөө л дээрх эзэн албатын проблем юм. Тэгэхээр энд бид компанийн засаглал биш корпорацийн засаглал гэж ярих нь зөв болохыг ойлгож болно. Компанид эзэд нь ч, албат нь ч нэг хүн байж болно. Харин корпораци буюу нээлттэй компанид хувьцаа эзэмшигч хэдэн зуугаар тоологдоно.

Ер нь засаглалыг хамгийн энгийнээр тодорхойлвол аливаа орцыг, гарц болгож байгаа процесс юм (Бэвир, 2018). НҮБ-ын тодорхойлолтоор засаглал гэдэг нь шийдвэр гаргах, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх процесс юм. Харин нэгэн нийтлэлдээ Фукуяма (2013)-ийн тодорхойлсноор засаглал гэдэг нь “төр хуулиа боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлэх,

үйлчилгээгээ хүргэх чадвар юм”. Энд Фукуяма засаглалыг зөвхөн нийтийн засаглалын хүрээнд л авч үзсэн байгааг анхаарах нь зүйтэй. Тэрээр энэ тодорхойлолтоо бүр энгийн байдлаар төр бол өөрийн үүргээ сайн эсвэл муу гүйцэтгэдэг байгууллага. Харин тэр гүйцэтгэлийг нь л засаглал гэж нэрлэнэ гэсэн юм.

Тэгэхээр дээрх Бэвирийн тодорхойлолтоос харахад засаглалыг хэмжихийн тулд орц, гарц, процедурын үзүүлэлтүүдийг хэмжих шаардлагатай болдог. Фукуяма (2013) дараах хэмжүүрүүдийг санал болгосон байдаг.

1. Процедурын хэмжүүрүүд, үүнд “Веберийн төрийн албаны модернизаци”
2. Хүний нөөц ба тэдний мэргэшсэн байдал зэргийг багтаасан чадавхын хэмжүүр
3. Гарцын хэмжүүр
4. Төрийн албаны бие даасан байдлын хэмжүүр. Тэгээд энэ дотроосоо чадавх болон бие даасан байдал хоёрыг хамгийн чухал үзүүлэлт гэж тэр үзсэн юм.

Засаглалыг хэмжих дээрх дөрвөн үзүүлэлтээс ч харсан, засаглалын үндсэн зарчмууд болох ил тод байдал, эгэх хариуцлага, тайлагнал зэргийг бодоод үзсэн ч гэсэн засаглал гэдэг нь аливаа нэгэн үр дүнд хүрч буй процесс юм байна гэдэг нь төвөггүй ойлгогддог. Ерөнхийлөгчийн, парламентийн засаглал гэж яриад байгаа хүмүүс энэ ялгааг бодоод үзээрэй.

НЭР ТОМЬЁОНЫ ЦААНА

Мэдээж нэр томьёо чухал боловч агуулга талаас нь ярилцах зүйл олон бий. Миний бодлоор засаглалын тухай ярихдаа хэд хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй мэт.

Нэгт. Засаглалын тухай ярихад бид хамгийн түрүүнд авлигын асуудлыг хөнддөг. Ер нь авлига үгүй болчихвол шууд сайн засаглалтай болчихуу? Энэ асуултад Фукуяма үгүй гэсэн хариулт өгсөн. Түүнийхээр ямар ч авлигагүй мөртлөө маш муу засаглал байж болно. Нөгөө талаасаа тодорхой хэмжээний авлигатай ч гэсэн сайн засаглал


байх боломжтой аж. Үүний жишээ нь Хятад. Хятадын төрийн албанд авлига гүн шингэсэн, уламжлалтай орон. Гэхдээ төрийн албаных нь шийдвэр гаргах, үр дүнд хүрэх чадвар нь өндөр учраас лигетимт чанараа хадгалсаар байна. Гэхдээ энд авлигыг үл тоо гэсэн санаа ерөөс үгүй. Гагцхүү авлига засаглалтай холбоотой асуудлын зөвхөн нэг нь гэдгийг л хэлж байгаа юм.

Хоёрт. Засаглал бол зөвхөн төр засгийн тухай юм уу, бизнесийн байгууллагын тухайд яригдах зүйл биш. Асуудалд шийдэл хайхдаа хүмүүс

ихэвчлэн энэ хоёроор хязгаарлах гээд байх нь элбэг. Засаглалын онолд үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм бол Эдийн засгийн салбарын Нобелийн шагнал хүртсэн цорын ганц эмэгтэй Элиноор Остром юм. Элиноор Остром олон орны жишээн дээр баталснаар нийтийн өмчийг хадгалж, хамгаалах ажлыг орон нутгийн бүлгүүд (community) нь төр засаг, зах зээлээс илүү хийж чаддаг гэнэ. Тэгэхийн тулд тодорхой нийгмийн

инстүүцүүд бий болох шаардлагатай. Манай бэлчээртэй холбоотой засаглалын асуудлын шийдэл нь энд байж болох юм.

Гуравт. Засаглалын тухай өнгөц биш өргөн хүрээнд ярихын тулд наад зах нь Дэлхийн банкнаас гаргадаг “Дэлхий дахины засаглалын индикаторууд”-д Монгол хаана явж байгааг харах хэрэгтэй.



(Эх сурвалж: Дэлхийн банк, 2019)

Эндээс харахад төр засгийн үр ашигтай байдал гэдэг үзүүлэлт нь хамгийн сул байна. Ер нь сүүлийн 10 гаруй жилд Монгол “Бананын бүгд найрамдах улс” болчихсон гэхэд буруудахгүй. Улс төрийн лидерүүдийн ярьдаг зүйл уул уурхай

л болчихлоо. Гэтэл төрийн албаны чадавх, үр ашигтай байдал зэрэг дээрх чухал засаглалын үзүүлэлтүүдийг анхаарах лидер харагдахгүй байгаа нь харамсалтай.

2019 оны 1-р сар

ҮНЭ: 19.900₮

Алтанхуягийн БАТ-ОРГИЛ

ХӨГЖЛИЙН ТУХАЙ ОНОЛУУД МОНГОЛЫН ХӨРСӨНД




Хөгжлийн тухай яриа, хэлэлцүүлэг, маргаан, нийтлэл олны анхаарлыг их татдаг ч өнөөдөр хөгжлийн талаар системтэй мэдлэг өгөх ном зохиол монгол хэл дээр тун ховор байна. Тиймд А.Бат-Оргилын энэ ном хөгжлийг сонирхдог олон хүнийг баярлуулах нь гарцаагүй.

Д.Энхбат



Залуу судлаач А.Бат-Оргил хөгжлийн тухай онолуудыг Монголын уншигчдад товч тодорхой, системтэйгээр хүргэж байна. Энэ ном бол анхдагч гэдгээрээ тун ач холбогдолтой.

Дефакто Д.Жаргалсайхан



ҮНЭГҮЙ ХҮРГЭЛТ
8602-4422



Интерном, Азхур, Мир номын бүх салбаруудаар худалдаалагдаж байна.



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 20 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.01.27-ны дугаар
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

БИЗНЕСМЕНҮҮДИЙГ БАРИВЧИЛСАН ШАЛТГААН



Ч.ДАВААНИАМ



С.БАЯР



Д.ДОРЛИГЖАВ



Т.ГАНБОЛД



Д.БАЯСГАЛАН



Үйл явдлын товч:

Өнгөрсөн Баасан гарагт Авлигатай Тэмцэх Газраас Петровис компанийн үүсгэн байгуулагч Ч.Давааням болон н.Сэцэнзориг гэсэн хүмүүсийг түр саатуулж байцаасан.

Уг хоёр хүнийг Ерөнхий сайд асан С.Баяртай холбоотой ба түүний хөрөнгийн урсгалыг мэддэг байж болзошгүй гэж шалгаж байгаа гэв.

Мөн Голомт банкны үүсгэн байгуулагчдын Д.Баясгаланг баривчлан саатуулсан. Шалтгаан нь Алтан Дорнод Монгол компанийн Т.Ганболд, Ерөнхий прокурор асан Д.Дорлигжав нарын яриатай холбоотой гэж хэвлэл мэдээллүүд бичиж байна.

Дүгнэлт тайлбар:

Эдгээр бизнесменүүдийг баривчилсан шалтгааныг та юу гэж бодож байна? Яагаад одоо гэж?

Д.Баясгалангийн баривчилгаа бол Ерөнхий Прокурор асан Д.Дорлигжавын хэрэгт холбоотой. Банк ба алтны уурхайгаас гарсан мөнгө. Ерөнхий Прокурор асан Д.Дорлигжав гэдэг хүн Алтан Дорнод Монгол компанийн захирал Т.Ганболд гэдэг хүнээс 10 сая доллар шаардсан, тэр мөнгө нь Голомт банкаар дамжсан гэдэгтэй холбогдож байгаа.

Улаанбаатар хотын газруудыг банкны эзэд авч ирсэн л дээ. Д.Баясгалан хүүхдийн паркийн газрыг өөрийн нэр дээр эзэмшдэг хүн. ХХБ-ны Д.Эрдэнэбилэг ХХБ-ыг УБ банктай хоёуланг нь эзэмшдэг хүн. Сүхбаатарын талбайн урд хэсэг УБ банкны хөрөнгө. Тагнуулын Ерөнхий Газрын урд талын талбай, Улаанбаатар зочид буудлын урд талын талбай, Ю.Цэдэнбалын хөшөө байгаа талбай, Б.Ширэндэв гуайн хөшөө байгаа талбай бүгд УБ банкны мэдэлд байдаг. М.Энхболдын дараа хотын дарга байсан Г.Мөнхбаяр гэдэг хүн ялагдсаныхаа дараа ийм шийдвэр гаргачихаад яваад өгсөн.

2010 онд Mongolian Mining Corporation Ухаа худгаар IPO хийж Хонг Конгд 600 гаруй сая долларын хөрөнгө босгосон түүнд Петровис ХХК 11.4 хувийн эзэмшилтэй гэсэн мэдээлэл байгаа. 2 жилийн дараа 2012 оны 2-р сард 2.4 хувиа зарж, тэр нь 70-80 орчим сая доллар болсон ба тэр мөнгөтэйгээ наашаа орж ирэх мөн дараахан нь Ерөнхий сайд асан С.Баярын хүүхдүүдэд Ч.Давааням гэдэг хүнээс хөрөнгө шилжсэн байна гэж хэлж байгаа.

Богино хугацаанд бариад буцаагаад сулладаг нь ямар нэгэн улс төрийн тохироо хийх зорилготой юу?

Монголд бизнес хийх ялангуяа газар, уул уурхай, банкны бизнес эрхлэхэд улс төрчдийн оролцоогүй явах боломжгүй болсон. Том бизнесийн эзэд өөрсдөө хууль тогтоогч, сайд болдог. Эсвэл улс төрчдийг худалдан авдаг. Бизнес төр хоёр ийм ойрхон болох нь авлигын эх

үүсвэр болдог. Нэгэнт улс төр бизнес хоёр хүчтэй барьцалдсан байхад энэ хоёрын хүчний харьцаа алдагдаж, бүлэглэлүүд хоорондоо байлдах үеэр ганц хоёр хэргийг ил болгож, баривчилгаа явуулаад сулладаг.

2017 онд шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 106 хэргээс 46 /43.3хувь/ эрүүгийн хэрэг шийдвэрлэж байсан бол 2018 онд нийт 224 хэрэг шүүхээр шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлснээс 84 /37.5 хувь/ хэргийг

шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн дүнтэй байна.

АТГ-ын үйл ажиллагаа идэвхижсэн нь уг газрын даргыг Ерөнхийлөгч солих хүсэлтэй байгаатай холбоотой юу?

Тэгж хэлж болохоор. Ямар ч гэсэн ИХ-ын дарга солигдоно. Тэгээд л харна даа. Нөгөө талаас нь харвал олон жилийн өмнөөс эхэлсэн хэдэн зуун хэргийг зөв шийдэхэд цаг хугацаа шаардагдана гэдгийг бас тооцох ёстой.

ТӨГРӨГИЙН ХАНШ 8.9 ХУВИАР СУЛАРСАН БАЙНА

Үйл явдлын товч:

Төв Банкны валютын нөөц 3.5 тэрбум ам.долларт хүрч байгаа ч өнгөрсөн онд төгрөгийн ханш 8.9 хувиар суларсан байна. 2018 онд 577 сая ам.долларын зээлийг хүүгийн хамт төлбөрт төлсөн. Мөн эдийн засаг тодорхой хэмжээгээр идэвхижсэн.


Төв Банкны мэргэжилтнүүд эдийн засаг сэргэснээс хэрэглээний импорт мөн хэрэглээний зээл нэмэгдсэн гэж тайлбарлаж байсан. Хэрэглээний зээл 40-50 хувь нэмэгдсэн байхад бизнесийн зээл төдийлөн өсөлтгүй байж. Үүний дагуу хэрэглээний зээлийн хугацааг энэ оноос 30 хүртэлх сар байхаар бууруулсан.

Дүгнэлт тайлбар:

Юуны өмнө бид олж байгаагаасаа ихийг хэрэглээндээ үрж байна гэдэгтэй та санал нийлэх үү?

Монголын бүх банкны активын 47 хувь нь зээл. 2010 онд 60 хувь байсан. Хэрэглээний зээлийн дундаж хүү 18 хувь, аж ахуй нэгжид 15.5 хувь байгаа. Зөвхөн хэрэглээний зээл гэхэд 45 хувиар өссөн байгаа. Хүмүүс гадаадаас худалдан авалт маш их хийж байгаа ба ялангуяа авто машины лизинг. Тэгэхээр зээлээрээ импортоор бүтээгдэхүүн аваад байгаа уялдаа байна. Хийсэн бүтээснээрээ бус бүтээгээгүй зүйлийнхээ орлогоор бүтээгдэхүүн аваад байна шүү дээ. Улс орны ард иргэдийн санхүүгийн боловсрол хэрэглээний соёлыг бий болгодог.

Эдийн засаг 6.6 хувиар өссөн, төгрөгийн ханш 8.9 хувиар унасан, инфляци 8 хувь болсон.



Эдийн засгийн нийт өсөлтөөсөө илүү долларын ханшийн асуудал эдийн засгийн гол асуудал болчихоод байна. Долларын ханш үүнээс илүү өсөх байхад Төв банк интервенц хийгээд байгаа байхгүй юу. 2018 онд алтны худалдан авалт сайн хийж 700-аад сая доллараар нөөцөө нэмсэн. Мөн 2017, 2018 онд нийт 970 сая доллар IMF-ийн хөтөлбөрийн дагуу орж ирсэн. Монголбанкны нийт валютын нөөц 3.5 тэрбум болсноос он гараад 20-оод хоногийн дотор 230 сая долларыг нь гаргаж зарсан байна. Үүний хүчээр бариад байна. Гэхдээ Монголбанк бүх нөөцөө гаргаад ч үүнийг зогсоож чадахгүй.

Зээлийн хүү өндөр учраас бизнесийн зээл өсөхгүй байна уу?

Ер нь бол татвар их байгаа. Татвар өндөр байгаа учраас улсын төсвийн орлого нэмэгдэж байна. Татвараа хуулийн дагуу авах ёстой ч нэмэхгүй байх ёстой. Өндөр татвар төлдөг өндөр хөгжсөн оронтой өөрсдийгөө харьцуулж болохгүй. Нийт

зээлийн 10 хувь нь муу зээл болсон. Барилга, уул уурхайн салбар дийлэнхийг нь эзэлж байгаа. Орон сууц, барилга борлогдохгүй байгаагийн гол

шалтгаан нь ипотекийн зээл. Ипотекийн зээлээс болж барилгын үнэ бодит хэмжээндээ очихгүй байгаа байхгүй юу.

ТӨРИЙН БАНКААР ДАМЖУУЛЖ МӨНГӨ УГААСАН УУ?



Д.БАЯРСАЙХАН



Үйл явдлын товч:

Төрийн банкны захирал Д.Баярсайхан 20 тэрбум төгрөгийн зээлийг барьцаа харгалзалгүй бага хүүтэй олгосон асуудлыг шалгаж байгаа талаар мэдээлэл гарсан. 20 тэрбум төгрөг гарсныг Сангийн сайд ч үнэн гэдгийг хэлсэн.

Төрийн банк, Хөгжлийн банк зэргээс зарим аж ахуйн нэгж, хувь хүн хуурамч хөрөнгийн үнэлгээ гаргаж ямар ч өрсөлдөөнгүйгээр, давуу тал олж зээл авч байна. Ингэхдээ хямд үнэтэй объектыг хэд дахин өндөр үнээр хөрөнгийн барьцаа болгож аль эсвэл шахдаг байна.

Дүгнэлт тайлбар:

Төрийн банкаар дамжуулж мөнгө угаасан гэсэн яг бодитой баримт бий юу?

БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Шинжиан шинфа” ХХК гэх нэртэй авто замын компанид 20

тэрбум төгрөгийн зээл олгосон асуудал яригдаж байна. Энэ хэрэгт холбоотойгоор Төрийн банкны ерөнхий захирал Д.Баярсайхан шалгагдаж, цагдан хоригдоод байгаа. Хөдөө байгаа үндсэн хөрөнгийг 150 саяар худалдаж аваад Төрийн банкнаас очоод 10 дахин өсгөж үнэлээд үүнийхээ 70-80 хувиар нь зээл авчихаж байна. Зээлээ төлж чадахгүй болмогц барьцааг нь хурааж авах гэхээр үнэн хэрэгтээ 150 саяар авсан хөрөнгө байдаг. Ийм зүйл зөвхөн эзэнгүй банкин дээр л тохиолдоно.

Ер нь Төрийн банкныг одоо хүртэл хувьчлахгүй байгаа шалтгаан юу вэ? Төрийн банк байх шаардлагатай юу?

Улс төрчдөд ашигтай учраас. Нэг удаа 20-оод орлогч захиралтай байсан шүү дээ. Ийм хэрэг гарах тусам муу зээл нэмэгдэж байгаа. Муу зээл зээлийн эрсдлийн сан байгуулж, зээлэх мөнгө улам багассаар байдаг.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх
боломжтой.

GOOGLE STORE



APP STORE





JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
✉ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com